


## 23

## Шилжин ирсэн ажилчид



Олон эрэгтэй, эмэгтэй хүмүүс, тэдний гэр бүл нэг хотоос нөгөө хот руу, нэг улсаас нөгөө рүү сайн ажил, сайн цалин, шинэ боломж хайн нүүдэллэхдээ олон төвөгтэй асуудал болон эрсдэлтэй нүүр тулдаг. Тэд шаргуу, илүү сайн ажилладаг ч цагаач ажилчид үйлдвэрийн гадна ч, дотор ч хуулийн дагуу болон хууль бусаар ялгаварлан гадуурхалтай нүүр тулж байдаг.

Шилжин ирсэн ажилчид нь бусад ажилчдын адил дараах эрхтэй:

- Аюулгүй амьдрах, аюулгүй ажлын нөхцөлөөр хангуулах, шударга цалин авах;
- Эрүүл мэндийн, нийгмийн, боловсролын үйлчилгээг гэр бүлийн гишүүддээ авах;
- Эх хэлээрээ эвлэлдэн нэгдэх, үйлдвэрчний эвлэл байгуулах;
- Хүчирхийлэх, хууль бусаар халагдах, нутаг буцаах зэрэг дарамт, сүрдүүлгээс ангид эрх чөлөөтэй байх.

Хамгийн чухал нь, аливаа хүн шилжин цагаачлалгүй төрөлх нутагтаа амьдрах, нийгэм, улс төр, шашны амьдралд эрх чөлөөтэй оролцох, хангалуун амьдрах газраа өөрөө сонгох эрхтэй.

## Эх нутгаа орхиж явахаасаа өмнө цагаачлалын талаар судлах

Очоод нүүр тулах төвөгтэй асуудлуудад бэлдэхдээ аялж, шинэ хот, өөр улсад очиход юу хүлээж байгааг урьдаас тооцсон байх хэрэгтэй. Хэрвээ таны өмнөөс өөр хүмүүс гэрээ хэлэлцээр хийж байгаа бол хөдөлмөрийн ямар заалтууд орсон талаар аль болох ихийг олж мэдэж аваарай. Хэрвээ боломжтой бол бичгээр үйлдсэн гэрээг хувилан авч, гэр бүлдээ эсвэл найздаа үлдээгээрэй. Цагаачлал, тухайн улс орны хөдөлмөрийн хууль, соёл ба зан заншил танд хэрхэн нөлөөлж болох талаар сурч мэдэж ав. Өөртөө юу авч явах талаар асуу.

## Зуучлагч ба хууль бус хүний наймаачид

Зуучлагчид нь ажилчид хэрэгтэй байгаа томоохон экспортын чиглэлийн үйлдвэрт ажилладаг. Тэд ажилтанд ажил олж өгснийхөө төлөө, ажил олгогчид ажилтан олж өгсний төлөө тус тусад нь хөлс авдаг. Зуучлагчид заримдаа нэг улсаас нөгөө улс руу хууль ёсны зөвшөөрөлгүй хүн зөөдөг хууль бус хүний наймаачидтай хамтарч ажилладаг. Шударга бус зуучлагчид болон хууль бус хүний наймаачид нь ажлын нөхцөл, аяллын талаар ихэвчлэн худал мэдээлэл өгдөг. Тэдний ярьсан зүйл бодит байдлаасаа хамаагүй зөрүүтэй байдаг. Тэд магадгүй таныг гэрээсээ гарсан даруй төлбөрөө өөрчилж, мөн маш аюултай нөхцөл байдалд оруулж болно.

### Өр тавьж ажилтай болох

Би Тайванийн үйлдвэрт ажиллах боломжтой болсондоо маш их баярлаж байв. Зуучлагч намайг Филиппинд гэртээ олдгоосоо илүү ихийг олох болно гэж амлаж байлаа.



Тиймээс Тайваньд намайг хүргэж өгөөрэй гэж хөдөлмөрийн биржид би гэр бүлээсээ зээлсэн мөнгөө өгсөн. Тэнд надад үйлдвэрийн ажил олж өгөхдөө илүү их мөнгө хүсэж буй өөр нэг зуучлагчтай би уулзсан. Надад өөр сонголт байгаагүй тул би түүнд долоо хоног бүр бага багаар нь төлье гэж зөвшөөрсөн. Удалгүй үйлдвэрийн дотуур байр нь өндөр үнэтэй, татварыг суутгаж тооцдог, миний гэрээ дуусах хүртэл хадгаламжийн суутгалтай болохыг би олж мэдсэн.

(үргэлжлэл)

Долоо хоног бүр төлбөрөө төлж, үлдсэн жаахан мөнгөөрөө амьдардаг байв. Би бүх өрөө төлж дуустлаа энд ажиллахаар үлдэх ёстой болов. Гэвч би энэ өрийг төлж дуустал хэдэн жил зарцуулах байв. Би ах, эгч, дүү, бас мөн гэртээ үлдсэн хүн бүрт хөдөлмөрийн зуучлалаас хол байгаарай гэж хэлсэн. Тэд маш гайхамшигтай сайхан амьдрал амладаг ч энэ нь огт худал юм.

## Дасгал

### Зуучлагчдын талаар мэдээлэл цуглуулах

Мэдээллийг түгээх нь хүмүүсийг шударга бус зуучлагчдаас хамгаалахад тусална.

1. Бусад ажилчид, бас тэдний гэр бүлээс танай орон нутагт ажилладаг зуучлагч, хууль бус наймаачдын талаар асуу.
  - Тэд эндхийнх үү эсвэл өөр газрынх уу? Тэднийг олоход амархан уу?
  - Тэд хэнд ажилладаг вэ?
  - Тэд хэрхэн төлбөрөө авдаг вэ?
  - Тэд ажилтан болон байгууллагаас хэр их төлбөр авдаг вэ?
  - Тэд юу амлаж, юу нийлүүлдэг вэ?
  - Тэд хэн нэгэнд хор учруулж эсвэл алдаа гаргаж байсан уу?
  - Тэдэнд итгэж болох уу?
2. Мэдээллээ бусадтай хуваалцсанаар танай орон нутгийн бүх хүн зуучлагчаа сонгох үедээ илүү сайн шийдвэр гаргаж чадна.
3. Ажиллагчдад хор хохирол учруулсан эсвэл хуурсан зуучлагчдын жагсаалт гаргаж сурталчил.



## Цагаачлалын талаар мэдээлэл цуглуулах

Хэрвээ та эсвэл таны мэддэг хэн нэгэн цагаачлахаар төлөвлөж байгаа бол өөрийн явах чиглэлд байгаа цагаачилсан хүмүүс эсвэл тэдний гэр бүл, олон нийтийн төв, сүм, эрүүл мэндийн төв, ТББ-ын талаар интернэтээс аль болох их мэдээлэл цуглуулж чадна. Энэ нь танд учирч болох асуудлуудаас зайлсхийх, бас урьдчилан мэдэхэд туслах болно.

Дараах зүйлсийн талаар олж мэдэхийг хичээ:

- **Танай улсын өөр хэсэгт нээлттэй ажил байгаа эсэх.** Засгийн газрын оффисоос асууж, сониноос хайж, бусад хүмүүстэй ярилц. Магадгүй та тийм хол цагаачлах шаардлагагүй ч байж болно.
- **Ажиллах нөхцөл, үнэ, орлого, аюул, бас хэр удаан тэндээ үлдэх ёстой болох** зэрэг цагаачлах үед үүсэх хүндрэлүүд, жинхэнэ ашиг тус нь юу байх вэ.
- **Зуучлагч, тээвэрлэгч, бас ажил олгогч, тэдний тусч, үнэнч байдал.** Таныг илүү сайн шийдвэр гаргахад тань тус болж чадах, хамаарах шалтгааныг мэдэж байх. Жишээлбэл, хэрвээ зуучлагч танд хэтэрхий сайхан ажил санал болгож байвал та энэхүү ажлыг хүлээн зөвшөөрөх эсэх талаар болгоомжтой байх хэрэгтэй.
- Хот эсвэл тухайн улсын очих газар нь тухайн төрлийн нээлттэй ажил, цагаач ажилтан ажиллах, амьдрах, **орон нутгийн ёс заншил, хэлний талаар**

**боломжтой байх**

• **Очих улс руугаа явахад төлөгдөх хураамж, олж авах зөвшөөрөл,** шаардагдах хүлээлгийн хугацаа зэрэг нь аяллын үйл явцад орно.

• **Хэрхэн эрүүл мэндийн үйлчилгээ авах.** Таны очих газар цагаач ажилчдад үнэ багатай эсвэл үнэгүй үйлчилгээ үзүүлэх боломжтой эсэх.

• **Банкны данс нээх, банкны ажиллах зарчмыг ойлгох,** ирээдүйдээ зориулж мөнгө хадгалж сурах, гэр лүүгээ хэрхэн мөнгө шилжүүлэх, гэр бүлийнхэндээ хэрхэн энэ мөнгийг зарцуулахыг ойлгоход туслах зэрэг мөнгөний зохицуулалт яаж хийх.

• **Шинэ улсад ЭСЯ, цагаачдын бүлэг, үйлдвэрчний эвлэл, хүний эрхийн бүлэг зэрэг нөөц бололцооны талаар гэрээний мэдээлэлд байгаа эсэх.** Онцгой нөхцөл тохиолдсон үед ашиглах гэр бүлийн гишүүдийн болон найзынхаа утасны дугаарыг цээжлэх.



## Шинэ газар тулгарах төвөгтэй асуудлуудад бэлдэх

Ажил олгогчид нь ажиллагчдыг цагаачилж, шилжин ирж ажиллахыг урамшуулж байгаа нэг шалтгаан нь тэд нутгийн хэлийг ойлгохгүй эсвэл тухайн улсын зан заншлыг мэдэхгүй, аль эсвэл тухайн улсын хуулиар хамгаалагдахгүй байж болох, мөн орон нутгийн ажиллагчдыг бодвол хянахад илүү хялбар байдал нь юм. Тиймээс цагаач ажилчид бусад ажилчдыг бодвол илүү их нийгмийн асуудал, бэрхшээлтэй нүүр тулдаг.

### Өөрсдийн түүхээ хуваалцах

Индонезийн Хөдөөгийн хөгжлийн сан (RDF) ТББ нь шилжин суурьших сонирхолтой хүмүүст зориулан үйлдвэрт ажил хадгалж байдаг. Тэд шилжин ирсэн ажилчдын эрхийн талаар судалж, зарим аюулыг олж илрүүлдэг. Хэрвээ тухайн хүн шилжин ажиллахаар шийдсэн бол түүнийг шинэ газарт амьдрах, гэр бүлийн харилцаанд нь анхаарал тавих, урт хугацаанд хол байх үед нь асуудлыг нь шийдвэрлэх, мөнгөө яаж зохицуулахад бэлддэг.

Ажиллагчид буцаж ирэх үед, RDF бусад шилжин ажиллахыг хүсэж байгаа хүмүүстэй өөрийн түүхийг хуваалцахыг дэмжиж, бусдыг шилжин ажиллахад хүндрэлтэй асуудалд эртнээс бэлдэж чаддаг.

Буцаж ирсэн ажилчид бизнес эрхэлж, зээлийн холбоо, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулахад суралцах ба бас дахин буцаж явахгүйгээр мөнгөө ухаалаг зарцуулах талаар сургалтад хамрагдаж болдог.

## Цагаачдын эсрэг хүчирхийлэл

Шинэ улс, орон руу хууль ёсны бичиг баримтгүй шилжин нүүх нь ажиллагчдыг хууль бус хүний наймаачид, түүнийг ашиглах гэсэн хүмүүсийн эрхшээлд оруулдаг. Ажиллагчид ихэвчлэн ганцаараа, цагдаад баригдахаас айсан байдгийн зэрэгцээ танил бус нөхцөл байдалд дасах гэж үйлээ үздэг. Харин нутгийн оршин суугчдын уур хилэн хөдөлж, тэдэнд айдас төрүүлснээс шилжин ирэгсдийг үзэн яддаг. (21-р бүлэг: Ялгаварлан гадуурхал хэсгийг үз)

Шилжин ирсэн эмэгтэйчүүдийн хувьд ихэвчлэн хүчирхийлэлд өртөх эрсдэлд ордог. Тэд маш болгоомжтой байлаа ч эрсдэлд ордог. Цагаачлах нь өөрөө эрсдэлтэй ч зуучлагч, хууль бус хүний наймаачид, ажлын гэрээ байгуулагчид, ажил олгогчид, түүнчлэн хууль сахиулагчид ч тэднийг хохироосныхоо дараа

шийтгүүлэхгүй өнгөрч чаддаг болохоор цагаач эмэгтэйчүүдийг онилдог. Заримдаа эмэгтэйчүүдэд үйлдвэрт ажил олж өгнө гэж хэлчихээд тэднийг хүчээр биеийг нь үнэлүүлэх ажилд оруулдаг. Эмэгтэйчүүдийн байгууллага ихэвчлэн аюулд орсон ба шилжин ирсэн эмэгтэйчүүдийг хоргодох байраар хангаж, тусалдаг. (22-р бүлэг: Хүчирхийлэл хэсгийг үз.)

## **Албадан буцаах буюу эх оронд нь хүчээр буцаах**

Олон улс орнууд өөрсдийн хөдөлмөрийн эдийн засгийг шилжин ирсэн ажиллагчдаар дамжуулан хөгжүүлэх гэж оролддог. Дарга нь бага цалин өгч, огт аюулгүй ажиллагааны дүрэмгүй, хамгаалах хэрэгсэл, хангамжгүй байлгаж, хариуцлагаас бултахыг оролддог. Хэрвээ ажилчид илүү сайн нөхцөл, цалингийн талаар санал хүсэлтээ илэрхийлэх юм бол дарга нь тэднийг албадан буцаана гэж сүрдүүлдэг.

Тэр ч бүү хэл ажиллах хууль ёсны бичиг баримттайгаар шинэ газар эсвэл улсад ирсэн ажилчид хүртэл заримдаа албадан буцаана гэх сүрдүүлгийн дор ажилладаг. Ихэвчлэн хууль зүйн туслалцаа өгдөг бүлэг эсвэл байгууллага нь шилжин ирсэн хүмүүс олноор ажиллаж байгаа газарт хандан зөвлөгөө санал болгодог. Ойр орчноосоо асууж аль нь хамгийн боломжийн үнэтэй, бас найдвартай болохыг олж мэд.

## **Хэл, соёл**

Хэрвээ та тухайн нутгийн хэлээр ярьдаггүй бол найз нөхөдтэй болж, нийгэмд зохицоход хүндрэлтэй байх болно. Орон нутгийн хэл, ёс заншлыг нь сурч авснаар өөрийгөө хамгаалах, бусад ажилчидтай ярилцах, тусламж дэмжлэг авах ба өгөхөд илүү хялбар болно. Гэвч мөн өөрийн хэл, соёлоороо баяр тэмдэглэх орон зайтай байх нь чухал юм.

Үйлдвэрчний эвлэл, ажилчдын байгууллагаас танай үйлдвэрт ажилладаг өөр хэлээр ярьдаг ажилчдын эх хэл дээр бичсэн материалыг орчуулж өгнө үү гэж хүс, ингэснээр бүх ажилтан оролцож чадна. Та уулзалтад оролцохдоо орчуулагчтай байснаар шилжин ирсэн ажилчдыг ажилд илүү идэвхтэй оролцоход нь тусалж чадна.

## Орон сууц ба тээвэрлэлт

Үйлдвэрүүд ажилчдадаа амьдрах газар олох асуудлыг хялбар болгож, дотуур байр санал болгодог ч учир дутагдалтай байдаг. 32-р бүлэг: Амьдрах таатай газрын төлөө илүү сайн орон сууцтай болохын тулд хэрхэн зохион байгуулалтад орох тухай санааг үзнэ үү.

**Бангладешт ажилчид үйлдвэрийн дотуур байрнаас илүү аюулгүй, бас хямд нийтийн байр бий болгосон.**



## Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж

Зарим үйлдвэр эмнэлгийн үйлчилгээтэй. Гэхдээ ихэвчлэн анхан шатны тусламж олгох хэмжээнд байдаг. Үйлдвэр нь эмч нарт цалин өгдөг тул ихэвчлэн ажлаас үүдэлтэй эрүүл мэндийн асуудлыг үйлдвэрээс цалинждаг эмч нар хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг. Гэхдээ үйлдвэрийн гадуур эрүүл мэндийн үйлчилгээ ашиглах нь шилжиж ирсэн ажилчдад хүндрэлтэй байдаг. Бичиг баримтгүй ажилчид эрүүл мэндийн байгууллага руу явах юм бол цагаачлалын албанд хүргэгдэнэ гэж айдаг.

Хэдийгээр эрүүл мэндийн байгууллагыг засгийн газар удирддаг боловч тэд таны талаар цагаачлалын албанд мэдээлнэ гэсэн үг биш юм. Шилжин ирсэн ажилчдад хууль ёсны байдал, хэл болон соёл, бас шашны итгэл үнэмшлээс үл хамааран хямд болон үнэгүй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг газар бий. Бусад шилжин ирсэн ажилчид, үйлдвэрчний эвлэл, сүмээс нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээг хаанаас авч болох талаар асуу.

Зарим эрүүл мэндийн хөтөлбөр шилжин ирсэн ажилчдад тодорхой хэдэн үйлчилгээ буюу нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдээлэл санал болгодог. Шилжин ирсэн ажилчид ажилладаг бусад байгууллага нь ерөнхийдөө эрүүл мэндийн үйлчилгээ санал болгодоггүй боловч бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ), бас ДОХ-ын үнэгүй шинжилгээ, түүнчлэн үнэгүй эм, бэлгэвчээр хангадаг. Асуухаас битгий ай.

## Гэр бүлтэйгээ холбоо барих нь утга учиртай

Ард үлдсэн гэр бүл, олон нийтийн дэмжлэггүйгээр амьдрах нь ганцаардмал, стресстэй, бас хэцүү бэрх байх болно. Гэр лүүгээ мөнгө явуулах дарамт нь хүндрэлтэй байдал үүсгэж, заримдаа гэр бүлийн харилцааг илүү хэцүү болгодог. Ард үлдсэн гэр бүлтэйгээ холбогдох арга олох нь стресс болон бусад сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг багасгахад тусална. (27-р бүлэг. Стресс ба сэтгэцийн эрүүл мэнд хэсгийг үз.)

Бид шилжин ирсэн ажилчдад олон үнэгүй семинар санал болгодог. Хамгийн түгээмэл нь тэдэнд интернэт кафе компьютер ашиглан гэр бүлтэйгээ хэрхэн холбогдож болохыг харуулдаг. Энэ нь харьцангуй хямд ба тогтмол гэр бүл рүүгээ ярьж болдог. Бид мөн тэдэнд данс нээж, мөнгө шилжүүлэхэд нь тусалдаг. Ингэснээр тэд ижил хэлжээний мөнгө сар бүр илгээж чаддаг. Хэрвээ тэд явуулах мөнгө муутай байвал мөнгө багатай үедээ зориулж хадгалдаг. Тэдний гэр бүл хэр ихийг хүсэн хүлээж байгааг мэдсэнээр илүү стресс багатай болдог.




### Шинэ газар дахь таны амьдрал

Өөрийгөө шинэ орчин нөхцөлөөс хамгаалах зөвлөмж:

- **Чухал бичиг баримтын эх болон хуулбарыг хадгал.** Үргэлж өөрийн паспорт, ажлын зөвшөөрөл, бас бусад хувийн бичиг баримтаа хадгал. Тэдгээрийг ажил олгогч эсвэл зуучлагчид битгий өг. Ажил олгогч нь таны бичиг баримтыг авч болно, иймд нэг хуулбарыг өөрийн улсад, гэртээ, бас илүү нэг хувийг өөртөө үлдээ;
- Өөрийн ойлгохгүй байгаа эсвэл хүлээн зөвшөөрөхгүй байгаа бичиг баримт дээр **гарын үсэг бүү зур;**
- **Орон нутгийн хэлийг анхан шатны түвшинд сур.** Хэрвээ та мэддэг бол бусад ажилчдад тухайн хэлний анхан шатны үг хэллэгийг зааж өг;
- **Ажил олгогчоор таны ажлын үүрэг ба ажлын нөхцөл байдлыг хэлүүл;**

- **Өөрийн ажилласан цагийн бүртгэл, цалин, бас суутгалыг хөтөл;**

- **Хэрвээ таныг өртэй гэж хэлсэн бол энэхүү мэдээлэл нь зөв эсэх, яагаад гэдгийг асуу. Хэрвээ тоо хэмжээ нь буруу гэж бодож байвал та ажилчдыг дэмжих бүлгээс тусламж хүс;**



- **Та гар дээрээ хүлээн аваагүй цалинг авсан гэж гарын үсэг бүү зур;**

- **Ажил олгогчоор өөрийн цалингаас битгий “хадгаламж” хийлгэ.** Эсвэл таны цалингаас таны гэр рүү мөнгө битгий шилжүүлүүл. Хамгийн чухал нь ганцаараа битгий бай: сүм, олон нийтийн байгууллага, үйлдвэрчний эвлэл эсвэл цагдаа руу очиход тань тусалж чадах сүлжээ рүү яв;

- **Ганцаардал, сэтгэл санааны тавгүйтлээ багасгахын тулд шинэ найзтай бол;**

- **Мөнгөө аюулгүй хадгалж, зөв зарцуулж сур:** өөрийн ирээдүй эсвэл онцгой нөхцөлд зориулж хэсгийг нь хадгал, бүгдийг гэр лүүгээ битгий явуул, ард үлдсэн гэр бүлийнхэндээ мөнгөө зохицуулж сурахыг зааж өг.

**Санаж ав: Та өөрийн бүх орлого, хадгаламж, эд хөрөнгө, гэр бүлийн гишүүдээ аван эх орон руугаа бүрмөсөн буцах эрхтэй.**

## Эвлэлдэн нэгдэх эрх

Зарим засгийн газар, үйлдвэрчний эвлэл нь шилжин ирсэн ажилчдыг үйлдвэрчний эвлэлд нэгдэхийг зөвшөөрдөггүй ба орон нутгийн ажиллагчид нь, магадгүй тэд энд үлдэхээр төлөвлөөгүй тул эвлэлдэн нэгдэх сонирхолгүй гэж боддог. Гэвч шилжин ирсэн ажилчид нь эвлэлдэн нэгдэж, бас өөрсдийн орны үйл ажиллагааны тухай хувийн туршлагаар үйлдвэрчний эвлэлийн ажилд тус нэмэр болж чадна.

## Өөрийн эрх ба нөөц бололцооны талаар сурах

Улс бүр хууль ёсны бичиг баримтгүй ч шилжин ирсэн ажилчдад нөлөөлөхүйц хөдөлмөрийн хуультай байдаг. Ажилчдын байгууллага, бусад ажилчид, засгийн газар эсвэл интернэтээс судалж, өөрийн эрхийн талаар мэдэж ав. Эдгээр нь мөн аль байгууллага танд эрүүл мэндийн тусламж үзүүлэх болон хэл сурахад туслах эсвэл та халагдвал тус болж чадах сайн газруудыг олоход хэрэг болно.



### Шилжин ирсэн ажилчдын эрх



НҮБ-ын хүний эрхийн түгээмэл тунхаглалд шилжин ирсэн ажилчдыг оруулан бүх хүний эрхийг зааж өгсөн байдаг.

НҮБ-ын Шилжин ирсэн ажилчид, тэдний гэр бүлийн эрхийг хамгаалах конвенцод заахдаа бүх шилжин ирсэн ажилчид, тэдний гэр бүлийн гишүүд нь:

- Хуулийн дагуу хамгаалуулах эрхтэй.
- Үндэстэн хамаарахгүйгээр ажил (цаг, цалин, бас илүү цаг), бас нийгмийн хамгаалалд орох эрхтэй.
- Соёлын, шашны, бас холбоо тогтоох эрх чөлөөний эрх олгогдоно.
- Хүчирхийлэл, заналхийлэл, айлган сүрдүүлэлт, бас албадан хөдөлмөрөөс хамгаалагдах болно.
- Үйлдвэрчний эвлэлд нэгдэх, зохион байгуулалтад орох эрхтэй байна.

ОУХБ-ын Шилжин ирсэн ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн конвенц (№97), Шилжин ирсэн ажилчдад (№143)-д засгийн газар дараах зүйлийг заавал санал болгоно:



## Шилжин ирсэн ажилчдын эрх

(үргэлжлэл)



- Шилжин ирэгч хүмүүст үнэгүй туслалцаа, мэдээллээр үйлчлэх;
- Шилжин ирэгч, аялагч, явах гэж байгаа хүмүүсийг хүлээн авах боломжтой байх;
- Шилжин ирэгч, түүний гэр бүлийн гишүүдэд эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг байх;
- Орон нутгийн ажилчидтай адил хөдөлмөрийн болон хүний эрхтэй байх.


Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага НҮБ, ОУХБ-ын үүргийг Хавсралт А-д тайлбарлав.

## Нийтлэг асуудлын талаар бусад ажилчидтай ярилцах

Хэдийгээр ажлын байрны онцлогтой уялдан хүйс, нас, гарал угсаа зэрэг ялгаа байж болох ч үйлдвэрийн бүх ажилчдад нөлөөлж байгаа нийтлэг асуудалд бага цалин, эрүүл бус эсвэл аюултай нөхцөл байдал, албадан илүү цагаар ажиллуулах зэрэг зүйлс багтдаг.

Цаг гарган бусад ажилчидтай тэдний өмнө тулгарч буй асуудлын талаар ярилц. Нэг хүнд нөлөөлж байгаа асуудал амархан бусдад нөлөөлж болно.

Үйлдвэрийн бусад ажилчидтай харилцаа холбоогоо сайжруулснаар харьцангуй бага ганцаардаж, стресс багатай байхад тусалж чадна. Мөн бие биенийхээ талаар мэдээлэлтэй болж хотын аюултай хэсгүүд, хямд бараа худалдан авах дэлгүүрүүд, эрүүл мэндийн төвүүд болон



цагдаагийн газрыг харуулсан газрын зурагтай байснаар нөөц бололцоогоо сайжруулж чадна.

### **Хоосон шөнө, ганцаараа биш**

Намайг Шиаомей гэдэг. Би үйлдвэрт ажиллахаар Шенжен рүү нүүсэн. Би энд ирэхдээ маш их гунигтай байсан. Надад ямар ч найз байхгүй. Би гэр бүлийнхэндээ энэ тухай хэлмээр байвч тэд санаа зовох байх гээд хэлээгүй. Би үнэндээ үйлдвэрт ажиллахыг огтхон ч хүсэхгүй байна. Би том болоод радиод ажиллахыг мөрөөддөг байсан. Би энд нүүж ирэх үедээ надад ямар л чөлөөт цаг гарна орон нутгийн радио руу очиж тэдэнд туслахыг санал болгодог байв. Нэг өдөр радиогийн хөтлөгч өвчтэй байсан учир тэд намайг хөтөлбөрийн хөтлөгч хийх үү гэж асуусан. Юу ярихаа мэдэхгүй байсан учраас би өөрийн үйлдвэр дэх амьдралын тухай ярьж эхэлсэн. Би ганцаардаж байгаагаа, бас үйлдвэрийн нөхцөл сайнгүй байгаа талаар ярьсан. Үйлдвэрийн эзэд энэ нэвтрүүлгийг сонсоод маргааш нь намайг ажлаас халсан. Гэтэл радиогийн эзэн миний нэвтрүүлгийг маш олон хүн сонссоныг надад хэлсэн. Тэгээд тэд намайг ажлаас халсныг хэлэх үед надад шинэ ажил санал болгосон.

Миний нэвтрүүлгийн нэр “Хоосон шөнө, ганцаараа биш” гэдэг. Шилжин ирсэн залуу эмэгтэй ажилчдад “ганцаараа” юм шиг санагдах үед нь тэдний амьдралын төвөгтэй асуудлуудыг хэн нэгэн ойлгодог, тэдний хөгжил баясал, бас гуниг харууслыг хуваалцах орон зайг бий болгосон. Бид ажилчдын эрх, бас Шенжен дахь нээлттэй байгаа нөөц бололцооны талаар болон хаанаас интернэт кафе олж гэр бүлтэйгээ холбоо тогтоох, хаана хэл сурч болох, хэрхэн өөрсдийгөө хамгаалах болон бусад олон зүйлсийн талаар ярилцдаг.

## **Нийгмийн бүлэг байгуулах**

Маш олон ажилчид өөрсдийн гэр бүл, найз нөхдөө даган шинэ газар шилжин ирдэг. Та амралтын өдрөөрөө үндэсний хоолоо хуваалцах, ажлын байранд нүүр тулж байгаа асуудлуудаа хэлэлцэх, гэрээсээ мэдээ сонсох, түүнчлэн орон нутгийн түргэн тусламжийн газар, сургуульд туслах зэргээр хамтдаа цагийг өнгөрүүлж эхэл. Шинэ орчныхонтой ажилласнаар та өөрийн соёл болон гэр орны холбоо харилцаагаа тогтмолжуулж байх зуураа өөртөө болон шилжин ирсэн ажилчдын илүү сайн нөхцөл байдлын төлөө зохион байгуулалт хийж чадна.


## Шилжин ирсэн ажилчдад зориулсан нийгмийн төвүүд

Шри Ланкад 1995 онд Үндэсний Ажилчдын Конгресс (NWC) шилжин ирсэн ажилчдад үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэлийг нээлттэй болгов. Гэвч шилжин ирсэн ажилчдыг экспортын чиглэлийн үйлдвэр дотор амаргүй сорилт хүлээж байсан. Олонх нь үйл ажиллагаанд орохоос айж байв. Тэд нэгэнт л үйлдвэрийн байранд амьдардаг тул дарга нь тэдний чөлөөт цагийг удирдаж, тэднийг маш их ажиллуулдаг байв. Дарга нь ажилчдыг хэрвээ үйлдвэрчний эвлэлд нэгдэх юм бол халж, нутаг руу нь буцаана гэж сүрдүүлдэг байв.

Шилжин ирсэн ажилчдад зохион байгуулалтад орох аюулгүй орон зай өгөхийн тулд NWC үйлдвэрийн байрнаас гадна талд байрлалтай “Нөхөрлөлийн байшин” бий болгов. Ажилчид тэндээс ном, сэтгүүл авч, бусад ажилчидтай ярилцан, телевиз үзэж, бас хөдөлмөрийн хуулийн талаар мэдээлэл олж авч чаддаг байв. Тэнд ажилчдад зориулсан эрүүл мэндийн сургалт явуулж, үйлдвэрчний эвлэлийн талаар ярилцлагад орохыг урьдаг байв.

Тэд мөн ажилчдыг өөрсдийн ажил, амьдралдаа илүү эрх мэдэлтэй, бас өөрсдийн үйлдвэртээ манлайлагчид болохыг нь дэмжихийг хүсэж байв.

Би анх үйлдвэрчний эвлэлийн талаар NWC-ийн Нөхөрлөлийн байшингаас сонсож мэдсэн. Би тиймээ номын санд орохоор очоод ажилчдын эрхийн талаар сургалтад суух боломжтойг олж мэдсэн. Би 3 жилийн дараа NWC-ийн гишүүн болж бусад ажилчидтай хамтран үйл ажиллагаа зохион байгуулж эхэлсэн.



## Шилжин ирсэн ажилчдыг үйлдвэрчний хөдөлгөөний нэг хэсэг болгох

Шилжин ирсэн ажилчид нь ихэвчлэн ажлын хамгийн хүнд нөхцөл, өчүүхэн бага цалин, бас нутаг буцаах айдсын дунд, ялангуяа тэдэнд хууль ёсны бичиг баримт байхгүй бол хүчирхийлэл зэрэгт өртөж байдаг. Шилжин ирсэн ажилчид зохион байгуулалтад орохгүй бол ажил олгогчид нь тэдэнд хамгийн бага цалинг өгч болно гэж боддог. Хэдий тийм ч үйлдвэрчний эвлэл, ажилчдын бусад байгууллагууд шилжин ирсэн ажилчдын эрхийн төлөө тэмцэж, эдгээр нөхцөл байдлыг арилгах, засгийн газраас хөдөлмөрийн хууль, стандартуудаа бүх ажилтанд хамааралтайгаар мөрдүүл гэж шаарддаг.

Жишээлбэл, АНУ-ын Хөдөлмөрийн хуулийн холбоо шилжин ирсэн ажилчдын эрхийг хамгаалахын тулд Олон улсын ажилчдын эв санааны нэгдлийн өдрийг 5 сарын 1-нд (Майн нэгний баяр гэдгээрээ олонд танигдсан) тэмдэглэхээр шийдсэн юм. Майн нэгний баярын энэ өдөр Хөдөлмөрийн хуулийн холбоо шилжин ирсэн ажилчид нь боловсрол эзэмших боломжтой байх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, орон сууцтай байх асуудлыг АНУ-ын Засгийн газраас шаардах, шилжин ирсэн ажилчдын нөхцөл байдлыг сайжруулах кампанит ажлыг эхлүүлсэн юм.



Үйлдвэрчний эвлэл нь шилжин ирсэн ажилчдын ажлын байрны байгууллага болон нийгмийн хөдөлгөөнийг нэгтгэх хүчин чармайлт гаргаснаар нэлээд их хүчирхэгжсэн юм. Өөр өөр үндэстэн ястан эсвэл өөр хэлтэй ажилчид хамтран ажиллаж сурах үед дарга нар нь тэдний холбоог арьс өнгөний үзлээр өрсөлдүүлэн хувааж, султгаж чадахааргүй болсон юм. Үйлдвэр доторх өөр өөр хэлтэй ажилчид холбоо харилцаатай байснаар юу болж байгаа талаар бүгд мэдэх болж, ажиллагчид нь үйлдвэрчний эвлэлд буцаан мэдээлэл дамжуулах болов. Үйлдвэрчний эвлэл нь дотоод болон гадны ажлын байрны бүх хүмүүсийн эрх тэгш байдлын төлөөх байр суурьдаа хатуу зогсон тэмцэх үед энэ нь ирээдүйд гишүүд нь тэмцэлд ялалт байгуулахад тус болж чадах хүндлэл, итгэл, бас дэмжлэгийг бий болгосон юм.

### **Тайланд дахь шилжин ирсэн мьянмар ажилчдын холбоо**

Сандар Мьянмараас Тайланд руу Валуй Тренд Компанийн Мае Сот дахь хувцасны үйлдвэрт ажиллахаар хил давжээ. Шилжин ирсэн ажилчид нь нутгийн ажилчидтай яг адил тоо хэмжээ бүхий ажил гүйцэтгэж байсан ч тайланд ажилчдын цалингийн талаас багыг авдаг байв. Мөн түүнчлэн бүх ажилчид Тайландын хөдөлмөрийн хуулиар бүрэн эрхээ хангуулах ёстой байтал тэд ажиллах зөвшөөрөлтэй байсан ч гэсэн ажил олгогч нь ажилчдын ажиллах зөвшөөрлийн эх хувийг хадгалдаг байв. Хэрвээ мьянмар ажилчид өөрсдийн эрхийг шаардвал тэднийг халдаг, нутаг буцаадаг эсвэл бүр цагдаа, хөлснийхнөөр хороолгодог байв. Ойролцоох үйлдвэрт тэднийг эвлэлдэн нэгдсэн иймэрхүү үйл ажиллагаа хийхгүй байхыг анхааруулж, нэг эрэгтэйн амь насанд хүрч, гурван эмэгтэй ажилтныг хүчиндсэн байв.

Сандар нутаг буцаагдах эсвэл халдлагад өртөхөөс айж байсан боловч тэр өөрийн болон бусдын эрхийн төлөө тэмцэх цаг болсон гэдгийг мэдэж байв. Тэр бусад ажилчидтай ганцаарчлан уулзаж, тэдний асуудлууд юу байв, илүү сайн нөхцөлийн төлөө тэмцэх сонирхол тэдэнд байна уу, үгүй юу гэдгийг олж мэдэв. Энэ үеэр тэр хүний эрхийн талаар Юанг Чи Оогийн ажилчдын холбооны (YCOWA) сургалтад хамрагдаж, Тайланд дахь Мьянмарын ажилчдын үйл ажиллагааг дэмждэг байв. Тэр бусад ажилчдад YCOWA холбооны талаар ярьж ойлгуулахаар нууц уулзалтуудыг хийж, удалгүй тэдэнтэй олон ажилтан нэгдэв. YCOWA нь ажилчдыг ажлаа орхин илүү сайн цалин, ажлын нөхцөлийг шаардах тэмцлийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцуулав. Ажил олгогч нь үйлдвэрийн 119 ажилтан нэгэн зэрэг ажлаа орхих үед маш их балмагдав. Тэр шилжин ирсэн ажилчдыг ийм үйл ажиллагаа хийнэ гэж огт бодоогүй байв.

(үргэлжлэл)

Холбоо ажилчдыг төлөөлөн эзэнтэй тохиролцоо хийх алхам хийв. Сайн төлөвлөсөн кампанит ажлын үеэр үндэсний болон олон улсын байгууллагууд, олон нийтийн дэмжлэгийг оролцуулан ажилчид ахин дахин сайжруулан боловсруулсан шинэ холбооны гэрээг байгуулж чадсан юм. Ажил олгогч өмнө нь өгдөг байснаас хоёр дахин илүү хөдөлмөрийн хөлс, цалин өгөх, илүү цагийг тооцно гэдгээ амлав. Мөн тэдний ажиллах зөвшөөрлийн эх хувийг буцаан өгснөөр ажилчид өөрсдийн ажил болон амьдралаа удирдаж чадахаар болов.